

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



ДОРНОД АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДОО-2025/001/ШТА-СТА-ТЕЗ

2025 ОН

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгт, дүрслэлийн товъёог	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Аудитын шалгуур үзүүлэлт	3
Аудитын багийн бүрэлдэхүүн	4
БҮЛЭГ 1. ДОРНОД АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БАЙНА.	5-6
БҮЛЭГ 2. ДОРНОД АЙМГИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН ТӨЛӨВЛӨСНӨӨС 9.3 ХУВИАР ДАВЖ БИЕЛСЭН БАЙНА	6-7
БҮЛЭГ 3. АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА 86.6 ХУВЬ БУЮУ 92,429.4 САЯ ТӨГРӨГИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА.....	7-12
БҮЛЭГ 4. ШИЛЭН ДАНСНЫ БОЛОН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ.....	12
БҮЛЭГ 5. САНХҮҮГИЙН БАТАЛГААЖУУЛАХ ТАЙЛАНГИЙН АУДИТААР АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН	12
БҮЛЭГ 6. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ.....	13
ДҮГНЭЛТ:	14
ҮАГ-т хүргүүлсэн санал:	14
ЗӨВЛӨМЖ:	15
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ДОА	Дорнод аймаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
НА	Нийцлийн аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЯ	Сангийн яам
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч

Дүрслэлийн товъёог

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсвийн тэнцэл	5
Хүснэгт 2	Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	6
Хүснэгт 3	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл	6
Хүснэгт 4	Зардлыг суурь хязгаартай харьцуулсан харьцуулалт	7
Хүснэгт 5	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Хүснэгт 6	Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэл	9
Хүснэгт 7	Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл хэрэгжилт	10

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасныг тус тус үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын зорилт

Дорнод аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн зорилт үр нөлөөтэй хэрэгжсэн, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Аудитын хамарсан хүрээ

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д заасны дагуу Дорнод аймгийн Засаг даргын бэлтгэсэн Орон нутгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн 2024 оны төсвийн гүйцэтгэл;
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн 2024 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ;
- Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагчдын 2024 онд хэрэгжүүлсэн төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээ;
- Шилэн дансны болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт;
- Өмнөх оны зөвлөмжийн биелэлт.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэлээ. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан баталж, аудитын горим сорилыг хэрэгжүүллээ. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч болон бусад холбогдох хэлтэс, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, судалгаа, тоон мэдээлэл авах, түүвэрлэлт, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ, харьцуулалт хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа. Аудитын тайланд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн гүйцэтгэл, Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнг нэгтгэсэн болно. Аудитын холбогдох мэдээлэл, ажлын баримтыг хавсаргав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Тухайн жилийн төсвийн бодлого, чиглэл, зарчим
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд
- Улсын Их Хурлын 2020 оны "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоол

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам” 29 дүгээр тогтоол

Аудитын багийн бүрэлдэхүүн

Дорнод аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан баталгаажуулж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, Б.Оюунхэрлэн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1. ДОРНОД АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАЖ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУСГАСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БАЙНА.

1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ нь Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Дорнод аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан байна.

1.2 Дорнод аймгийн 2024 оны төсвийг аймгийн ИТХ-ын 2023 оны 19/11 дүгээр тогтоолоор батлан, 2024 оны 7-р сарын 05-ны өдрийн 22/01, 2024 оны 10-р сарын 25-ны өдрийн 02/02 дугаар тогтоолуудаар 2 удаа өөрчлөлт хийсэн байна.

1.3 Аймгийн 2024 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 106,756.1 сая төгрөг, тэнцвэржүүлсэн зарлагыг 104,137.6 сая төгрөгөөр тооцож, төсвийн тэнцлийг 2,619.1 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 4,886.8 төгрөгийн ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Төсвийн тэнцэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	106,756.7	97,316.2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	104,137.6	92,429.4
Нийт тэнцэл	2,619.1	4,886.8

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

БҮЛЭГ 2. ДОРНОД АЙМГИЙН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН ТӨЛӨВЛӨСНӨӨС 9.3 ХУВИАР ДАВЖ БИЕЛСЭН БАЙНА.

2.1 Аймгийн татварын нийт орлого 9.3 хувиар буюу 5,264.4 сая төгрөгөөр давж биелсэн ч зарим нэр төрлийн орлого 2,624.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 17,636.2 сая төгрөг буюу 31.2 хувиар нэмэгдүүлэн баталсан байна.

Нийт татварын орлого 5,264.4 сая төгрөг буюу 9.3 хувиар давж биелсэн ч 7 нэр төрлийн орлого 2,624.3 сая (Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 1,300.2 сая, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 120.6 сая, Малын тоо толгойн албан татвар 180.8 сая, Түгээмэл тархацтай ашигт малтмал 44.1 сая, Хог хаягдлын үйлчилгээний хураамж 296.5 сая, Дуудлага худалдааны орлого 624.2 сая, Газрын төлбөр 57.9 сая) төгрөгөөр тасарсан байна.

Дүрслэл 1. /сая төгрөгөөр/

д/д	Албан татвар, төлбөр хураамжийн нэр	2024 он			Гүйцэтгэлийн хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
1	Цалин хөлс, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөрлөх	29,197.4	32,480.7	(3,283.3)	111.2
2	Үйл ажиллагааны орлого	908.6	1,519.8	(611.2)	167.3
3	Хөрөнгийн орлого	1,492.7	1,834.0	(341.3)	122.9
4	Шууд бус орлого	2,808.8	4,820.7	(2,011.9)	171.6
5	ХХОАТ-ын буцаан олголт	(1,391.9)	(1,391.9)	(0.0)	100.0
6	ААН-ийн орлогын албан татвар	8,000.0	6,699.8	1,300.2	83.7
7	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,035.8	1,915.1	120.6	94.1
8	Бууны албан татвар	40.7	41.8	(1.1)	102.8
9	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	500.0	667.9	(167.9)	133.6
10	Малын тоо толгойн албан татвар	1,585.1	1,404.4	180.7	88.6
11	Улсын тэмдэгийн хураамж	549.8	1,521.4	(971.6)	276.7
12	Түгээмэл тархацтай ашигт малтмал	66.4	22.4	44.1	33.6

ДОРНОД АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

13	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,317.6	1,021.1	296.5	77.5
14	Газрын төлбөр	3,483.0	3,425.1	57.9	98.3
15	Дуудлага худалдаа	954.0	329.8	624.2	34.6
16	Ойн нөөц ашигласны төлбөр	19.0	20.5	(1.5)	107.8
17	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	208.7	213.7	(5.0)	102.4
18	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	5,001.4	5,495.1	(493.8)	109.9
Нийт		56,777.1	62,041.5	(5,264.4)	109.3

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Шууд бус орлого 2,011.9 сая төгрөгөөр давж биелсэн нь 2024 онд Эрдэнэс таван толгойн ногдол ашиг олгосонтой холбоотой байна.

Аж ахуй нэгжийн орлогын албан татвар 1,300.2 сая төгрөгөөр тасарсан нь уул уурхайн компани болох "Шинь Шинь" ХХК, "Меланж" ХХК-аас төвлөрүүлэхээр төлөвлөсөн татвар төлөвлөсөн хэмжээндээ хүрээгүйтэй холбоотой байна.

Малын тоо толгойн албан татвар 180.7 сая төгрөгөөр тасарсан нь тус аймагт өвөлжилтийн байдал хүндэрсэнтэй холбоотой байна.

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сүүлийн 5 жилийн байдлаар авч үзэхэд цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар сүүлийн 5 жил 6-19 хувиар, улсын тэмдэгтийн хураамж сүүлийн 2 жил 176.0-246.0 хувиар, ус рашаан ашигласны төлбөр сүүлийн 2 жил 9.0-70.0 хувиар тус тус давж биелсэн бол аж ахуй нэгжийн орлогын албан татвар сүүлийн 3 жилд тасралтгүй 11-37.6 хувиар тасарсан байна.

2.2 ОНХНС-гаас тайлант жилд аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох 25,422.0 сая төгрөг шилжүүлэхээс 1,306.8 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу олгосон байна.

Хүснэгт 1. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Сумдын нэр	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Зөрүү
1	Баян-Уул	719.5	695.0	24.5
2	Баяндун	860.7	811.0	49.7
3	Баянтүмэн	1,306.0	993.8	312.2
4	Булган	476.9	452.6	24.3
5	Гурванзагал	400.8	387.3	13.5
6	Дашбалбар	1,420.1	888.1	532.0
7	Матад	3,732.1	3,223.7	508.4
8	Сэргэлэн	409.2	325.9	83.3
9	Хөлөнбуйр	318.3	307.8	10.5
10	Хэрлэн	2,966.1	2,859.6	106.5
11	Чойбалсан	1,160.0	1,098.8	61.2
12	Чулуунхороот	501.6	484.6	17.0
13	Цагаан-Овоо	1,037.2	742.3	294.9
14	Халхгол	2,432.8	2,147.9	284.9
15	Аймгийн ОНХС	7,680.7	8,696.8	1,016.1
Дүн		25,422.0	24,115.2	1,306.8

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

2.4 Төсвийн ерөнхийлөн захирагч нь тайлант онд 17 газрын тос, уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 5,470.0 сая төгрөгийн хандив тусламж авахаар төлөвлөн гэрээ байгуулсан байна. Тайлант хугацаанд тус аж ахуйн нэгжүүдээс 3,646.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд гүйцэтгэл нь 63.5 хувьтай байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч 12 аж ахуй нэгж нь хандив тусламжийн 1,823.2 сая төгрөгийг байгуулсан гэрээний дагуу төвлөрүүлээгүй байна.

"Монголын алт Мак" ХХК - 40.0 сая төгрөг, "Адуунчулуун" ХХК - 40.0 сая төгрөг, "ТОУУ" ХХК - 5.0 сая төгрөг, "Сүхжин" ХХК - 5.0 сая төгрөг, "Дун уянга" ХХК - 20.0 сая төгрөг, "Дамбат" ХХК - 20.0 сая төгрөг, "Петрочайна Дачинтамсаг" ХХК - 1,058.2 сая төгрөг, "Зэст өндөр" ХХК

- 20.0 сая төгрөг, “Дорнын хүдэр” ХХК - 50.0 сая төгрөг, “Хөх дэл инвест” ХХК - 50.0 сая төгрөг, “Меланж” ХХК - 500.0 сая төгрөг, “Ам Та Тү” ХХК - 15.0 сая төгрөг

БҮЛЭГ 3. АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА 86.6 ХУВЬ БУЮУ 92,429.4 САЯ ТӨГРӨГИЙН ГҮЙЦЭТГЭЛТЭЙ БАЙНА.

3.1 Аймгийн төсвийн суурь зардлыг сангийн яамны хянасан дүнгээс 214.4 сая төгрөгөөр бууруулан 41,019.7 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 2. Зардлыг суурь хязгаартай харьцуулсан харьцуулалт. /сая.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Сангийн яамны хянасан төсөв	2024 оны батлагдсан төсөв	Зөрүү
Орон нутгийн төсвийн нийт суурь зардал	41,234.4	41,019.7	(214.7)
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	581.9	945.9	363.9
Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	2,925.0	2,795.4	(129.6)
Аймгийн Засаг даргын Тамгын газар	9,085.0	6,411.6	(2,673.5)
Сумын Засаг даргын Тамгын газар	18,801.9	23,732.6	4,930.7
Санхүүгийн хяналт, аудитын алба	364.5	541.2	176.7
Орон нутгийн өмчийн газар	365.0	253.0	(111.9)
Худалдан авах ажиллагааны газар	385.8	266.4	(119.4)
Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	3,847.5	2,395.4	(1,452.1)
Үүнээс: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	2,151.9	1,016.5	(1,135.4)
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1,695.6	1,378.9	(316.7)
Ойн анги /Халхгол, Баян-Уул, Булган сум/	346.2	290.3	(55.9)
Хот тохижуулах газар	2,085.9	1,560.9	(525.0)
Чойбалсан хөгжил ОНӨҮГ	2,085.9	1,560.9	(525.0)
Аймгийн Засаг даргын нөөцийн сан	594.0	1,221.3	627.3
Аймгийн халамжийн сан	337.7	185.0	(152.6)
Авто замын сан	1,513.9	420.6	(1,093.2)

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Сангийн яамны хянасан хязгаараас орон тоог 18 (аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 4, аймгийн Засаг даргын Тамгын газар 14) нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

3.2 Аймгийн төсвийн нийт зарлага 86.6 хувь буюу 92,429.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Нийт зардлын 54 хувийг урсгал зардал, 46 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна.

Хүснэгт 3. Зардлын төлөвлөлт, гүйцэтгэл. /сая.төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРДАЛ БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	106,756.8	92,429.4	14,327.4
21	Урсгал зардал	53,559.3	49,903.1	3,656.3
210	Бараа үйлчилгээний зардал	48,129.9	44,685.6	3,444.3
211	Хүү	224.8	224.8	-
212	Татаас	62.8	62.8	-
213	Урсгал шилжүүлэг	5,141.9	4,930.0	212.0
22	Хөрөнгийн зардал	51,644.4	42,486.4	9,158.0
221	Их засвар	1,330.9	1,243.5	87.4
223	Бусад хөрөнгө	50,313.5	41,242.9	9,070.6
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	1,553.1	40.0	1,513.1
230	Эргэж төлөгдөх зээл	1,553.1	40.0	1,513.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	106,756.8	93,333.9	13,422.9

ДОРНОД АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

32	Орон нутгийн төсвөөс санхүүжих	86,816.2	87,125.5	(309.3)
321	Орон нутгийн төсвөөс	61,394.2	63,010.2	(1,616.0)
322	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	25,422.0	24,115.2	1,306.8
35	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	14,255.6	1,813.3	12,442.3
351	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	986.0	1,573.8	(587.8)
352	Туслах үйл ажиллагааны орлогоос	190.9	239.5	(48.6)
353	Урьд оны үлдэгдлээс	12,907.7	-	12,907.7
354	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	171.0	-	171.0
36	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	5,685.0	4,395.1	1,289.9
360	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	5,685.0	4,395.1	1,289.9
IV	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,469.4	(6,469.4)
V	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,373.8	(7,373.8)

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

3.3 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Дорнод аймгийн улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 2,619.1 сая төгрөгөөр баталсныг бүрэн шилжүүлсэн байна.

3.4 Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан сумын чиг үүрэгт нийцээгүй арга хэмжээ, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй 186.1 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэнд холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Хэрлэн сумын ЗДТГ улс төрийн намуудад орон нутгийн төсвөөс 31.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 94.8 сая төгрөгөөр орон сууц /Гадаадын иргэн харьяатын газар/ худалдан авсан, Хэрлэн сумын ИТХ Хэрлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024 оны А/03 захирамжаар хурлын 31 төлөөлөгчдөд хууль, тогтоомжид заагдаагүй 60.3 сая төгрөгийн урамшуулал олгосон.

3.5 Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөр Малын халдварт өвчин, гамшгаас сэргийлэх, үйл ажиллагаанд 1,211.4 сая төгрөг, гал түймэр болон зудад нэрвэгдсэн хувь хүн болон айл өрхийн нийт 50 хүнд тусламж үзүүлэхэд 56.4 сая төгрөг, Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг батлах дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан Эдийн засаг, хөгжлийн яамны шийдвэрээр Улаанбаатар хотноо 2024 оны 02 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Монгол Улсын эдийн засгийн чуулган-Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөн"-д оролцогчдын зардал, зудтай сумын автомашины засварын зардалд 135.5 сая төгрөг, нийт 1,403.2 сая төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамд"-д нийцэж байна.

3.6 Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансны нийт зардал 2,905.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас хуваарилсан 1,809.7 сая төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн 146.7 сая төгрөгийн, ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй хөрөнгийн 262.4 сая төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 687.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлснээс 2,857.5 сая төгрөгийн зарцуулалт хийж, 48.3 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

Хүснэгт 6. Нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэл.

/сая төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРДАЛ БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,905.8

ДОРНОД АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

21	Урсгал зардал	2,885.8
210	Бараа үйлчилгээний зардал	2,788.5
213	Урсгал шилжүүлэг	97.3
22	Хөрөнгийн зардал	20.0
223	Бусад хөрөнгө	20.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,905.8
131	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,905.8
1311	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	146.7
1312	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	262.4
1313	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгасан	1,809.7
1314	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд	687.0

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.

3.7 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд 30 төсөл, арга хэмжээнд 6,093.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 2,166.3 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 1,808.6 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн, 989.9 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Хэрэгжилт 50.3 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн аудитын байгууллагаас 2024 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр хянагдаагүй 180.9 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг шинээр нэмж батлуулан хэрэгжүүлсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламж засвар, тохижилт 97.8 сая төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжийн халаалтын систем гадна дотор инженерийн шугам засвар, шинэчлэлт 83.1 сая төгрөг.

3.8 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 487 төсөл, арга хэмжээнд 38,269.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 31,762.4 сая төгрөгийн 379 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 2,622.9 сая төгрөгийн 52 төсөл, арга хэмжээ дутуу хэрэгжсэн, 3,884.1 сая төгрөгийн 56 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Хэрэгжилт 83.0 хувьтай байна.

Хүснэгт 6. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл, хэрэгжилт

/сая төгрөгөөр/

№	Сумдын нэр	ТАХ		Бүрэн хэрэгжсэн		Дутуу хэрэгжсэн		Хэрэгжээгүй		Хэрэгжилтийн хувь /дундаж/
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Баян-Уул	32	1,016.3	29	997.1	-	-	3	19.2	98.1
2	Баяндун	22	1,036.6	18	912.8	3	83.8	1	40.0	88.1
3	Баянтүмэн	44	1,498.1	34	1,064.7	4	24.9	6	408.5	71.1
4	Булган	23	651.2	13	504.6	3	61.6	7	85.0	77.5
5	Гурванзагал	20	706.9	16	677.2	4	29.7	-	-	95.8
6	Дашбалбар	19	3,437.9	15	2,737.4	2	272.1	2	428.4	79.6
7	Матад	49	3,934.3	43	3,587.8	3	30.3	3	316.2	91.2
8	Сэргэлэн	20	851.9	19	657.2	-	-	1	194.7	77.1
9	Хөлөнбуйр	18	428.5	13	255.8	2	47.0	3	125.7	59.7
10	Хэрлэн	34	3,308.6	29	2,993.6	3	237.1	2	77.9	90.5
11	Чойбалсан	22	1,216.4	14	650.0	-	-	8	566.4	53.4

ДОРНОД АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

12	Чулуунхороот	33	641.8	31	625.6	-	-	2	16.2	97.5
13	Цагаан-Овоо	23	1,383.2	18	933.1	4	39.3	1	410.8	67.5
14	Халхгол	37	2,665.3	28	2,542.4	1	22.9	8	100.0	95.4
15	Аймгийн ОНХС	91	15,492.4	59	12,623.1	23	1,774.2	9	1,095.1	81.5
	Дүн	487	38,269.4	379	31,762.4	52	2,622.9	56	3,884.1	83.0

Эх сурвалж: Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан.

Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар ОНХС-гийн төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой 7,839.7 сая төгрөгийн 51 зөрчил илэрсэн байна.

1. Сум, багийн иргэдээс санал авч эрэмбэлээгүй төлөвлөж, хэрэгжүүлсэн 4,550.3 сая төгрөгийн (Дашбалбар сум 108.6 сая төгрөгийн 2, Баян-Уул сум 60.5 сая төгрөгийн 3, Матад сум 4,364.5 сая төгрөгийн 33, Баянтүмэн сум 16.7 сая төгрөгийн 1) 39 төсөл арга хэмжээ;

2. Төрийн аудитын байгууллагаас 2024 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтээр хянагдаагүй дараах төсөл арга хэмжээг шинээр нэмж хэрэгжүүлсэн 1,389.3 сая төгрөгийн (Хэрлэн сум 7 багт орон нутгийн өмчийн спорт заалны барилгын засварт 939.9 сая төгрөг, Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн барилгын их засварт 250.9 сая төгрөг, Булган сумын ЕБС-ийн спорт заалны барилгын засварт 150.4 сая төгрөг, Булган сумын хатуу хучилттай 27 км автозамын арчлалтыг хийх 48.0 сая төгрөг) 4 төсөл арга хэмжээ

3. Төсөвт өртгийг нэмэгдүүлсэн 1,900.1 сая төгрөгийн (Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн засвар, тохижилт 127.8 сая төгрөг, Хэрлэн сум 10 дугаар багт дулаан дамжуулах шугам сүлжээ 489.7 сая төгрөг, Чойбалсангийн гудамжны авто замын засвар, арчлалтын ажилд 181.0 сая төгрөг, “Дорнод НАА” ОНӨААТҮГ-ын зүүн талын Чойбалсангийн гудамжны босоо тэнхлэгийн авто замын арчлалтын ажил 184.0 сая төгрөг, Хэрлэн сум 5 дугаар багийн Ялалт гүүрнээс урагш Мөнхөт чиглэлийн авто замын арчлалт, сайжруулалт 392.1 сая төгрөг, Хэрлэн сумаас Баян-Уул сумын чиглэлийн орон нутгийн чанартай 50км авто замын засвар, арчлалт 132.9 сая төгрөг) 8 төсөл арга хэмжээ.

3.9 Хөдөө аж ахуйн сангийн хөрөнгөөр 410 ширхэг хүлэмжийг 709.2 сая төгрөгөөр худалдан авч 14 сумын иргэн, хоршоололд олгосон байна.

Хөдөө аж ахуйн сангийн хөрөнгөөр 2024 онд 1,038.9 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр 1,043.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөдөө аж ахуйн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх "Арван мянган хүлэмж" төслийн хүрээнд 410 ширхэг хүлэмжийг 709.2 сая төгрөгөөр худалдан авч 14 сумын иргэн, хоршоололд олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчим 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх”, 13 дугаар зүйлийн 13.3.2-т “**хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ**”, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т “**Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно**” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Тухайн төсөл арга хэмжээг Дорнод аймгийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар тусламжийн шинжтэй хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй хөрөнгийг төсөвт тусгахгүй байх албан шаардлага, Дорнод аймгийн 2024 оны төсвийн төсөлд хийсэн аудитаар хасах санал тус тус хүргүүлсэн боловч хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.10 Сумдад ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилго хангагдахгүй байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр олгосон зээлийн 2,596.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд үүний 1,172.3 сая төгрөг буюу 45.1 хувь нь хугацаа хэтэрсэн төлөвтэй байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас нийт 1,553.1 сая төгрөгийн зээл олгохоор 12 сум төлөвлөсөн ч Хэрлэн сум 40.0 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд бусад сумд зээл олгоогүй, Чулуунхороот, Чойбалсан сумд хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийг төлөвлөн батлуулаагүй байна. Энэ нь сумдад үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодоор дамжуулан ажлын байр бий болгох, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг сайжруулах, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах хоршоо хөгжүүлэх сангийн зорилго хангагдахгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-д заасан орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, орон нутагт хоршоо, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон сумдын Засаг даргатай хамтран сургалт зохион байгуулах чиг үүргүүдээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.11 Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд Дорнод аймагт 153 хоршоо шинээр байгуулагдсан бөгөөд тайлант хугацаанд 92 хоршоонд 13,516.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Уг зээлийг Хоршооны тухай хуулийн 42 дугаар зүйл, Засгийн газрын "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 2024 оны 166 дугаар тогтоолын дагуу Засгийн газраас ХААН банк, Төрийн банк, Хас банкаар дамжуулан олгосон байна.

БҮЛЭГ 4. ШИЛЭН ДАНСНЫ БОЛОН ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

4.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг иж бүрэн, хуульд заасан хугацаанд байршуулахгүй байна.

Дорнод аймгийн Засаг даргын хамрах хүрээний 22 байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,960.4 сая төгрөгийн 22 зөрчил илрүүлж, 1,587.0 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 1,373.4 сая төгрөгийн зөрчилд 17 зөвлөмж өгч ажиллалаа.

Хөрөнгө зарцуулалттай холбоотой шийдвэр, төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбар, хугацаа хоцордог зөрчил арилахгүй байна.

4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 91.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Дорнод аймгийн Засаг даргын хамрах хүрээний 13 байгууллагын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 91.0 сая төгрөгийн 13 зөрчил илрүүлж, 12.0 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоон, 79.0 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

Аудитын илрүүлэлт:

1. Баянтүмэн сумын ИТХ 1.1 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан,
2. Матад сумын ЗДТГ 1.9 сая төгрөгийн тушаал шийдвэргүй нэмэгдэл цалин олгосон,
3. Дашбалбар сумын ЗДТГ Онцгой байдлын газраас түймэрт зарцуулсан шатахууны 5.3 сая төгрөг, төрийн албан хаагчаас орон сууцны халаалтын үнийн 0.5 сая төгрөг нийт 5.8 сая төгрөгийг нэхэмжлэн авсан орлогоор шатахууны талон худалдан авч нөөцөлсөн боловч бараа материалын дансанд бүртгээгүй,
4. Мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан 19.7 сая төгрөг (Хэрлэн сумын ЗДТГ 2.7 сая төгрөг, Гурванзагал сумын ЗДТГ 2.5 сая төгрөг, Чойбалсан сумын ЗДТГ 2.2 сая төгрөг, Дорнод аймгийн ЗДТГ 4.6 сая төгрөг, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба 1.7 сая төгрөг, Сэргэлэн сумын ЗДТГ 6.0 сая төгрөг)-ийг олгосон.
5. Дорнод аймгийн ИТХ нь орон тоог Сангийн яамны хянасан дүнгээс 3 орон тоогоор хэтрүүлэн төлөвлөсөн, бодит гүйцэтгэлээр 14 орон тоотой.
6. Хэрлэн сумын ИТХ сумын хурлын төлөөлөгчдөд 60.3 сая төгрөгийн урамшуулал олгосон,

БҮЛЭГ 5. САНХҮҮГИЙН БАТАЛГААЖУУЛАХ ТАЙЛАНГИЙН АУДИТААР АВСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

5.1 Ерөнхий чиглэлийн судалгаанд орон нутгийн 36 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 18 байгууллагыг хамруулан, 6 байгууллагатай холбоотой 335.0 сая төгрөгийн зөрчил илэрсэнд холбогдох арга хэмжээг авч ажилласан.

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой 196.7 сая төгрөгийн (Баянтүмэн сумын ЗДТГ нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг давсан зардлыг шууд гэрээ байгуулсан, Баянтүмэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь худалдан авахаар төлөвлөсөн 125.0 сая төгрөгийн 5 бараа, ажил үйлчилгээг зохион байгуулаагүй, Дорнод НАА ОНӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь заалтыг зөрчиж ХАА зохион байгуулсан) 3 зөрчил.

2. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/-тай холбоотой судалгаагаар 138.3 сая төгрөгийн ("Дорнод нийтийн аж ахуй" ОНӨААТҮГ ерөнхий ба удирдлагын зардалтай холбоотой 4.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, борлуулалт маркетингийн зардалтай холбоотой 133.5 сая төгрөг 2 албан шаардлага) 3 зөрчил.

3. Орон тоотой холбоотойгоор (Дорнод аймгийн ИТХ нь Сангийн яамны хянасан дүн 10 байхаас 3-аар хэтрүүлэн төлөвлөж, бодит гүйцэтгэлээр 14 орон тоотой, аймгийн ЗДТГ нь 14-өөр илүү) 2 зөрчил

5.2 Судалгаанаас харахад 12 сумдад 47 орон тоо дутагдалтай байна.

Баяндун сум -3, Баян-Уул -2, Баянтүмэн сум -2, Булган сум -3, Дашбалбар сум -5, Гурванзагал сум -5, Матад сум -4, Халхгол сум -7, Хэрлэн сум -5, Хөлөнбуйр сум -5, Цагаан-Овоо сум -4, Чойбалсан сум -2

БҮЛЭГ 6. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ 71.1 ХУВИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ БАЙНА.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 71.1 хувийн хэрэгжилттэй байна. Үүнд:

1. Төрийн аудитын байгууллагаар хянагдаагүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх албан шаардлагын гүйцэтгэл – 66.4 хувийн хэрэгжилттэй.
2. Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй, хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй хөрөнгийг төсөвт тусгахгүй байх албан шаардлагын хэрэгжилт - 50 хувийн хэрэгжилттэй.
3. Татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэн ажиллах зөвлөмж – 50 хувийн хэрэгжилттэй.
4. Сумдын төсвийн орлогын төлөвлөлтөд арга зүйн зөвлөгөө өгч, хяналтыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж -100 хувийн хэрэгжилттэй.
5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрэх үр дүнг ханган ажиллах зөвлөмж – 88.9 хувийн хэрэгжилттэй.

Аудитаар нийт 11,640.9 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 709.2 сая төгрөгийн 1 албан шаардлага, 10,931.7 сая төгрөгийн 8 зөвлөмж өгч ажиллалаа.

ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Дорнод аймгийн 2024 оны төсвийн гүйцэтгэл нь төсвийн тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангаж, бодлогын баримт бичгүүдэд тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.
2. Аймгийн татварын нийт орлого 9.3 хувиар буюу 5,264.4 сая төгрөгөөр давж биелсэн ч аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, малд ногдуулах татвар, үл хөдлөх хөрөнгийн татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, газрын төлбөр нь 2,624.3 сая төгрөгөөр тасарсан байна.
3. Аймгийн төсвийн нийт зарлага 86.6 хувь буюу 92,429.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
4. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар Дорнод аймгийн улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 2,619.1 сая төгрөгөөр баталсныг бүрэн шилжүүлсэн байна.
5. Хөдөө аж ахуйн сангийн хөрөнгөөр 410 ширхэг хүлэмжийг 709.2 сая төгрөгөөр худалдан авч 14 сумын иргэн, хоршоололд олгосон нь Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1 дэх заалттай нийцэхгүй байна.
6. Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүй байна.
7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 22 байгууллага нь Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, хуулийн хугацаанд байршуулаагүй байна.
8. Ерөнхий чиглэлийн судалгааг орон нутгийн 36 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот 18 байгууллагыг хамруулан авахад 6 байгууллагатай холбоотой 335.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.
9. Өмнөх аудитын шийдвэрийн биелэлт 71.1 хувийн хэрэгжилттэй байна.

ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА-д

1. Сумдад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах арга хэмжээ зохион байгуулж ажиллах.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтын дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллах.
3. Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж ажиллах.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн дагуу байгуулсан гэрээний төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж байх.
5. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээг бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн, хууль тогтоомжийн дагуу иргэдээс санал авч төлөвлөн, хэрэгжүүлэх.
6. Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-д "Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу хяналтыг хэрэгжүүлж ажиллах.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 21/18

Чойбалсан хот

Г Аудитын тайланг баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Дорнод аймгийн Засаг дарга, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газарт хүргүүлэхийг аудитын менежер (И.Сэмжидмаа)-д даалгасугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг Дорнод аймгийн Засаг дарга (Ш.Ёл)-д зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Д.Нармандах)-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2125010032